

Хичээл : 6-р ангийн “Монгол хэл”

Хичээлийн сэдэв: Жинхэнэ нэрийн утга

Асуулт1: Дараах өгүүлбэрт жинхэнэ нэр хэд байна вэ?

Цайдам хөндийн зүүн зах нь болсон хэсэг дэрс рүү эхээс гараад хэдхэн хоносон цайвар цагаан янзага дагуулсан шаргачин орж ирлээ.

А. 4

Б. 5

В. 6

Д. 7

Асуулт2: Дараах өгүүлбэрт буй үзэгдлийг заасан утгатай жинхэнэ нэрийг олоорой.

Хаврын хурц нар нэлээд дээр мандаад ойр орчмыг хөхөмдөг манан бүрхэж, өргөн талд байгаа юмс цөм зэрэглэн жирвэлзэж байлаа.

А. Хавар

Б. Тал

В. Нар

Д. Манан

Асуулт3 : Оноосон нэрийг ерийн нэртэй нь зөв харгалзуулаарай.

А. Отгонтэнгэр

1. аймаг

Б. Өвөрхангай

2. уул

В. Бат-Эрдэнэ

3. хамтлаг

Г. Харанга

4. сонин

Д.Өнөөдөр

5. хүн